



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 06 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Барилгын тусгай зөвшөөрлийг шинээр олгох,
нэмэлт ажлын төрлөөр олгох, сунгах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 15 дугаар зүйлийн 15.14.3, 15.14.6, Барилгын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.3, 20.5, 20.6, 33 дугаар зүйлийн 33.1.15 дахь заалт Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 147 дугаар тушаалаар батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, барилгын материалын үйлдвэрлэл, өргөх байгууламж, түүний эд ангийн үйлдвэрлэл, угсралт, засвар үйлчилгээ эрхлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, үйлчилгээний хөлс тогтоох, тэдгээрт хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ-ын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 21/855/ТЗ тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг нэгдүгээр, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг нэмэлт ажлын төрлөөр олгох байгууллагын жагсаалт”-ыг хоёрдугаар, “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг сунгах аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт”-ыг гуравдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Барилгын тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Гантулга/-т, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг хангуулж ажиллахыг “Монголын барилгын үндэсний ассоциаци” ТББ /Д.Цэрэнжигмэд/-д тус тус даалгасугай.



Б.МӨНХБААТАР


152210015

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн
06 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ШИНЭЭР ОЛГОХ АЖ
АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

| № | Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | Барилгын ажлын төрөл | Хугацаа |
|---|-------------------------------------|---|---------|
| 1 | "Нутгийн барилга" ХХК | Барилга угсралт, шинэ БА-2.1, 6.1, 6.2, 6.3, 6.4 | 5 |
| 2 | "Ногоон хөгжлийн зөв шийдэл" ХХК | Зураг төсөл, шинэ ЗТ-3.7 | 5 |
| 3 | "Росторг" ХХК | Зураг төсөл, шинэ ЗТ-2.1, 8.1 | 5 |
| 4 | "Бодь-интернэшнл" ХХК | Зураг төсөл, шинэ ЗТ-2.1, 8.1 | 5 |
| 5 | "Про Би Ар ДИ" ХХК | Зураг төсөл, шинэ ЗТ-2.1 | 5 |


Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн
06 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ НЭМЭЛТ АЖЛЫН ТӨРЛӨӨР
ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

| № | Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | Барилгын ажлын төрөл | Хугацаа |
|---|------------------------------------|--|---------|
| 1 | "Жаргалант дулаан" ХХК | Барилга угсралт, нэмэлт БА-2.2 | - |
| 2 | "Алтанбулаг трейд" ХХК | Барилга угсралт, нэмэлт БА-3.1, 7.1 | - |

Барилга, хот байгуулалтын сайдын
2021 оны 01 дугаар сарын 06-ны өдрийн
06.. дугаар тушаалын гуравдугаар хавсралт



**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ, БАРИЛГЫН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СУНГАХ АЖ АХУЙН
НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ**

| № | Аж ахуйн нэгж, байгууллагын нэр | Барилгын ажлын төрөл | Хугацаа |
|---|------------------------------------|--|---------|
| 1 | "Арвинзол констракшн" ХХК | Барилга угсралт, сунгалт БА-2.1, 6.1, 6.2, 6.3, 6.4 | 5 |
| 2 | "Алтанбулаг трейд" ХХК | Барилга угсралт, сунгалт БА-2.1, 3.4, 6.1, 6.2, 6.3, 6.4 | 5 |
| 3 | "Алтайн орд" ХХК | Барилга угсралт, сунгалт БА-2.1, 6.3, 6.4, 7.1 | 5 |
| 4 | "Кеестонресурс" ХХК | Зураг төсөл, сунгалт ЗТ-5.5 | 5 |
| 5 | "Батс-инженеринг" ХХК | Зураг төсөл, сунгалт ЗТ-3.6 | 5 |
| 6 | "Сант-од планинг" ХХК | Зураг төсөл, сунгалт ЗТ-4.1 | 5 |
| 7 | "Прожектмайнинг" ХХК | Зураг төсөл, сунгалт ЗТ-4.7 | 5 |
| 8 | "Номин трейдинг" ХХК | Өргөх байгууламж, сунгалт ӨБ-4.1, 4.2 | 5 |